

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Shinjenmagadlahui.ezshaudit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjenmagadlahui.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	
5.2 Албан шаардлага	
5.3 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 100

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Номын сангийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 81.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 0.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамжийн материал 3.6 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардал 1.8 хувийг, тэтгэвэрт гархад олгох албан хаагчид 36 сарын тэтгэмж төрөөс үзүүлэх дэмжлэгт 7.2 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 40 хувиар өссөн байна.

4525020160

Бусад асуудал

Дархан-Уул аймгийн Номын сан нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 13 нэр төрлийн арга хэмжээ төлөвлөж, 79 удаагийн үйл ажиллагааг хэрэгжилтийг 98.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,218,732.80</u>	<u>10,083,900.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,741,232.80	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,741,232.80	-
3121	Төгрөг	22,741,232.80	-
31211	Төрийн сангийн харилцах	22,741,232.80	-
35	БАРАА МАТЕРИАЛ	477,500.00	10,083,900.00
35410	Бичиг хэрэг	-	7,663,900.00
354	Хангамжийн материал	-	10,083,900.00
35440	Түлш, шатах тослох материал	477,500.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	2,420,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>428,699,909.22</u>	<u>527,673,994.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	428,699,909.22	527,673,994.96
392	Биет хөрөнгө	379,663,909.22	475,667,994.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	110,688,504.00	110,688,504.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,422,714.40)	(14,907,257.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,400,000.00	21,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,400,000.00)	(21,400,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,612,854.19	122,605,235.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,524,496.16)	(28,113,871.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,056,500.00	28,805,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,197,153.28)	(9,486,277.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,289,000.00	21,789,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,097,488.68)	(1,262,605.32)
39217	Ном	230,258,903.55	246,549,767.55
393	Биет бус хөрөнгө	49,036,000.00	52,006,000.00
39301	Програм хангамж	3,580,325.00	2,970,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,580,325.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	49,036,000.00	49,036,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>451,918,642.02</u>	<u>537,757,894.96</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>451,918,642.02</u>	<u>537,757,894.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	451,918,642.02	537,757,894.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	451,918,642.02	537,757,894.96
51101	Өмч: - төрийн	262,683,838.46	262,683,838.46
512	Хуримтлагдсан үр дүн	152,750,632.33	238,589,885.27
51210	Өмнөх үеийн үр дүн	94,542,673.54	152,750,632.33
51220	Тайлант үеийн үр дүн	58,207,958.79	85,839,252.94
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	36,484,171.23	36,484,171.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>451,918,642.02</u>	<u>537,757,894.96</u>

СТ-2А



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	509,583,308.68	771,056,114.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,718,920.00	119,322,042.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,718,920.00	119,322,042.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,000,000.00	18,322,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,834,000.00	18,322,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,166,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	10,718,920.00	91,716,042.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	-	9,284,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,864,388.68	651,734,072.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	461,935,988.68	638,678,072.85
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	461,935,988.68	638,678,072.85
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,928,400.00	13,056,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,928,400.00	13,056,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	451,375,349.89	685,216,861.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	451,375,349.89	685,216,861.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,021,652.39	576,824,363.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,699,569.70	432,824,757.37
210101	Үндсэн цалин	199,605,962.41	257,688,723.92
210102	Нэмэгдэл	56,394,058.87	105,556,265.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,833,363.91	34,231,025.86
210104	Урамшуулал	27,866,184.51	35,348,742.40
210105	Гэрээт ажлын хөлс		0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,559,200.00	54,105,800.00
210201	Тэтгэврийн даатгал	28,348,500.00	36,792,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,302,600.00	4,328,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,642,300.00	2,164,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	660,400.00	2,164,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,605,400.00	8,656,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,606,912.50	4,429,814.05
210301	Гэрэл, цахилгаан	546,664.24	602,362.71
210302	Түлш, халаалт	3,545,540.06	3,369,984.81
210303	Цэвэр, бохир ус	514,708.20	457,466.53
2104	Хангамж, бараа материалын зардал	20,742,056.76	17,543,726.87
210401	Бичиг хэрэг	9,556,970.00	11,974,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,591,000.00	2,837,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,055,776.76	920,866.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	108,000.00	364,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,417,810.00	1,447,360.00
210408	Бараа материал акталсны зардал	12,500.00	0.00
2105	Нормативт зардал	3,410,790.00	2,460,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	312,090.00	0.00
210502	Хоол, хүнс	3,098,700.00	2,460,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,672,300.00	5,728,905.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		0.00
210604	Урсгал засвар	3,672,300.00	5,728,905.00
2107	Томилолт, зочны зардал	118,000.00	2,698,600.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	118,000.00	2,698,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,603,042.00	17,904,072.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,516,630.00	15,597,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,340.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,420,000.00
210807	Газрын төлбөр	98,072.00	98,072.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,609,781.43	39,128,588.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,212,900.00	19,801,075.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,396,881.43	19,327,513.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,353,697.50	108,392,498.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,932,210.00	81,802,365.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,826,100.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	75,976,265.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэхдэмжлэг	34,182,210.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	23,963,852.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,963,852.41
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	421,487.50	2,626,280.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	421,487.50	2,626,280.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	58,207,958.79	85,839,252.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	58,207,958.79	85,839,252.94



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	498,864,388.68	670,056,072.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,000,000.00	18,322,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,000,000.00	18,322,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,000,000.00	18,322,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,834,000.00	18,322,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,166,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,864,388.68	651,734,072.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	461,935,988.68	638,678,072.85
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	461,935,988.68	638,678,072.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,928,400.00	13,056,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,928,400.00	13,056,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	440,455,968.46	666,211,748.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,455,968.46	666,211,748.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,455,968.46	557,819,250.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,699,569.70	432,824,757.37
210101	Үндсэн цалин	199,605,962.41	257,688,723.92
210102	Нэмэгдэл	56,394,058.87	105,556,265.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,833,363.91	34,231,025.86
210104	Урамшуулал	27,866,184.51	35,348,742.40
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,559,200.00	54,105,800.00
210201	Тэтгэврийн даатгал	28,348,500.00	36,792,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,302,600.00	4,328,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,642,300.00	2,164,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	660,400.00	2,164,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,605,400.00	8,656,900.00



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,606,912.50	4,429,814.05
210301	Гэрэл, цахилгаан	546,664.24	602,362.71
210302	Түлш, халаалт	3,545,540.06	3,369,984.81
210303	Цэвэр, бохир ус	514,708.20	457,466.53
2104	Хангамж, бараа материалын зардал	6,211,076.76	8,606,576.87
210401	Бичиг хэрэг	872,000.00	3,569,900.00
210402	Тээвэр, шатахуун	998,500.00	1,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,055,776.76	920,866.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	108,000.00	444,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,771,810.00
2105	Нормативт зардал	720,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,290,000.00	5,999,905.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,176,800.00	-
210604	Урсгал засвар	8,900,000.00	5,999,905.00
2107	Томилолт, зочны зардал	118,000.00	2,698,600.00
210702	Дотоод албан томилолт	118,000.00	2,698,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,460,412.00	28,323,197.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,374,000.00	26,016,725.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,340.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	1,420,000.00
210807	Газрын төлбөр	98,072.00	98,072.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,437,100.00	20,830,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,437,100.00	20,830,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,353,697.50	108,392,498.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,932,210.00	81,802,365.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,826,100.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	75,976,265.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	34,182,210.00	-



	дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	23,963,852.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,963,852.41
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	421,487.50	2,626,280.95
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	421,487.50	2,626,280.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>58,408,420.22</u>	3,844,324.20
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35,687,600.00	26,585,557.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,687,600.00	26,585,557.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	35,687,600.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,687,600.00	26,585,557.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(35,687,600.00)</u>	(26,585,557.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,720,820.22	(22,741,232.80)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,412.58	22,741,232.80
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,741,232.80	-



СТ-4А

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	262,683,838.46	36,484,171.23	94,542,673.54	393,710,683,.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	--
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,683,838.46	36,484,171.23	94,542,673.54	393,710,683,.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	58,207,958.79	58,207,958.79
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	262,683,838.46	36,484,171.23	152,750,632.33	451,918,642.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,683,838.46	36,484,171.23	152,750,632.33	451,918,642.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	85,839,252.94	85,839,252.94
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,683,838.46	36,484,171.23	238,589,885.27	537,757,894.96

ХТӨБ430 Ф 3022899

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ
/ Төгрөгөөр/

Дансны ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	676,734,100.00	692,797,305.65	16,063,205.65	102.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676,734,100.00	692,797,305.65	16,063,205.65	102.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,233,900.00	584,404,807.29	(6,829,092.71)	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,847,100.00	432,824,757.37	(22,342.63)	99.9
210101	Үндсэн цалин	260,655,000.00	257,688,723.92	(2,966,276.08)	98.8
210104	Урамшуулал	35,023,800.00	35,348,742.40	324,942.40	100.9
210201	Тэтгэврийн даатгал	36,792,000.00	36,792,000.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,328,500.00	4,328,500.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,508,000.00	602,362.71	(1,905,637.29)	24.0
210302	Түлш, халаалт	3,900,000.00	3,369,984.81	(530,015.19)	86.4
210303	Цэвэр, бохир ус	648,000.00	457,466.53	(190,533.47)	70.6
2104	Хангамж, бараа материалын зардал	16,897,500.00	14,204,433.87	(2,693,066.13)	84.0
210401	Бичиг хэрэг	6,800,000.00	3,569,900.00	(3,230,100.00)	52.5
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,900,000.00	100,000.00	105.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	920,866.87	20,866.87	102.3
210404	Ном, хэвлэл	5,400,000.00	5,597,857.00	197,857.00	103.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	197,500.00	444,000.00	246,500.00	224.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,771,810.00	(28,190.00)	98.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,880,300.00	13,867,700.00	(12,600.00)	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,810,200.00	26,016,725.00	(793,475.00)	97.0
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	95,400.00	(24,600.00)	79.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000.00	1,420,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,600,000.00	23,600,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,500,200.00	81,802,365.00	22,892,298.36	126.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,500,200.00	81,802,365.00	(3,697,835.00)	95.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,405,100.00	5,826,100.00	(2,579,000.00)	69.3
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг				-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	676,734,100.15	692,797,305.65	16,063,205.50	102.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18322000.00	18322000.00	0.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	18,322,000.00	18,322,000.00	0.00	-
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Номын сан нь "Төрөөс соёлын талаар баримтлах бодлого шийдвэрийг Аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, соёл танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулж, оюутан сурагчид, иргэд, уншигчдын оролцоог нэмэгдүүлэхийн төлөө бүхий л ажлаа чиглүүлэн цагийн нөхцөл байдалд тохируулан ажлын арга хэлбэрээ танхимын болон цахим хосолсон хэлбэрээр явуулж, номын сангийн таатай орчныг бүрдүүлж иргэд уншигчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг олон хэлбэрээр номын сангийн үйл ажиллагааг сурталчлан амжилттай ажиллах" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёл, олон түмний ажил
- Номын сан, ном зүйн мэдээлэл
- Сургалт, сурталчилгаа
- Фонд баяжилт
- Нүүдэл, зөөврийн номын сан фондод шинээр ирсэн болон тэмдэглэлт өдөрт зориулан нийт 72 удаа 3030 боть номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж фондын номыг сурталчилсан байна.
- Номын сангийн урагдаж гэмтсэн, салсан нийт 65 нэр төрлийн 88 боть номыг нааж, үдэж сэргээн засварлаад байна.
- Номын санд удаан суух боломжгүй болон бусад шалтгаантай 1163 уншигчид 1490 боть ном олгосон байна.
- Уншигчдад хүрч ажиллах зорилгоор зохион байгуулдаг Зөөврийн номын сангийн үйлчилгээг 19 удаа 1006 боть ном олгож үйлчилсэн байна.
- Төв номын сангийн 60 жилийн ойд зориулан "Нэг уншигч- Нэг ном" номын хандивын аян зарлаж 64 байгууллага, иргэдээс 868 боть номыг цуглуулаад байна.
- хаврын номын баярт 24 нэр төрлийн үйл ажиллагааг 59 удаа зохион байгуулж, 11,347 хүн оролцсон бол намрын номын баяраар 14 нэр төрлийн үйл ажиллагааг 28 удаа зохион байгуулж, 8961 хүнд соёл гэгээрүүлэх үйлчилгээ үзүүлэн, 5358 ном, үзүүлэн тараах материалыг сурталчилж, цахим контентыг 6 удаа хийж, 19017 хүн үзэж сонирхсон байна.
- Угийн бичгийн сургалт – 6 удаа, 293 хүн
- Бага насны хүүхдийн дунд "НОМ" сэдэвт илтгэлийн уралдааныг хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт тохируулан зохион байгуулж, 18 цэцэрлэг, сургуулийн 38 хүүхэд эцэг эх, багш нарын хамт амжилттай оролцлоо.
- Дархан-Уул аймгийн нийт иргэд, хүүхэд залуучуудын дунд 9 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл Монгол Ардын Ерөөл, магтаал, өв уламжлалыг сэргээх, таниулах зорилго бүхий видео бичлэгийн уралдаан зарласан билээ. Тус уралдаанд 6-17 насны 118 хүүхэд бичлэг ирүүлсэн
- "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2024" намрын номын баярын хүрээнд хүүхэд залуусын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх шинэ санаа, бүтээлч байдлыг шингээсэн гарын доорхи материал ашиглан "Гоёхон номын хавчуурга" бүтээх

уралдааныг зарласан бөгөөд тус уралдаанд ШШГГ-ын 435 дугаар ангиас-2, оюутан-4, Ерөнхий боловсролын 9 сургуулийн 297 сурагчийн 711 бүтээлээр оролцсон байна

- комик ном бүтээх уралдааныг зарлаж, 9 сургуулийн 56 хүүхдийн 79 бүтээлээр оролцсон байна.
- Дархан сумын Ахмадын хороотой хамтран "УНШИХАД УРАМ" монголын уран зохиолын дүрийн тоглолтын уралдааныг зохион байгуулж, 7 багийн 60 гаруй ахмадууд авьяас билгээ уралдуулан 2-3 минутын багийн мэндчилгээ болон 10-15 минутын Уран зохиолын дүрийн тоглолтыг толилуульж, 270 гаруй ахмад үзэж сонирхов.
- Үндэсний бичиг үсгийн баярт "Эх хэл бичиг мину", "Дэлхийн номын баярт", "Ном уншихын ач тус, "Цагаан сар" сэдвүүдээр эчнээ уншигчдын бага хурлын материал бэлдэж, 350 хувь хэвлэн уншигч иргэдэд түгээлээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 06 сарын 21-ний өдрийн "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох" тухай 240, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241-р тогтоолуудыг мөрдөж ажилласан.
- Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн журам шинэчлэн батлах тухай" тушаалыг 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс мөрдөж ажиллах
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 12 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх
- Монгол улсын сангийн сайдын "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ын журам шинэчлэн батлах тухай" 2023.12.12-ны А/229 тушаал
- Монгол улсын сангийн сайдын "Эдийн засгийн ангилал шинэчлэн батлах тухай" 2023.11.20-ны 211 дүгээр тушаал
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2023.10.13-ны 12 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Төв номын сан 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 174,144.1 мян төгрөгөөр буюу 19.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,741.2	-	(22,741.2)
Авлага	-	-	-
Бараа материал	477.5	10,083.9	10,083.9
Үндсэн хөрөнгө	428,699.9	527,673.9	98,974.0
Нийт хөрөнгө	451,918.6	537,757.8	85,839.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	451,918.6	537,757.8	85,839.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	451,918.6	537,757.8	85,839.2

Дээрх хүснэгтээс харахад Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 0 төгрөг ба төвлөрүүрэх шилжүүлэгт мянган төгрөг татагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,083.9 мянган төгрөг болж төсвийн хөрөнгөөр 27,532.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд үйл ажиллагаанд 9,284.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 602,844.0 мянган төгрөг болж 174,144.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 13,867.7 мянган төгрөгийг машин тоног төхөөрөмж болон 5,597.8 мянган төгрөгийн ном худалдан авч, хандиваар 10,693.0 мянган төгрөгийн номын фонд хүлээн авч, мөн харааны бэрхшээлтэй иргэдийн төсөлөөр 59,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, мөн аймгийн ЗДТГ аас 25,293.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тус тус хүлээн авсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийн-саналаас урсгал зардлыг 173,925.9 мянган төгрөгөөр бууруулж, 676,734.1 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслийн тусгасан дүнгээс ном хэвлэл болон тоног төхөөрөмж, тавилга, судалгааны ажлын зардлууд тус тус буурч орж ирсэн.

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 638,678.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 18,322.0 мянган төгрөг, нийт зарлагыг 638,678.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 638,678.0 мянган төгрөг, гүйцэтгэлд суурилсан үнэлгээний санхүүжилт 22,700.7 мянган төгрөг, орон нутгийн төсөв 13,056.0 мянган төгрөгийг нийт төсөв 676,734.1 мянган төгрөгийг тус тус санхүүжсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 692,797.3 мянган төгрөг буюу 102.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

		/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл Т
1	71702 соёл урлаг	1	80101- Үндсэн уйл ажиллагааны зардал	528,882.3	528,778.6	103.7	105.0
		2	80215- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардал	10,000.0	10,000.0	0.0	100.0
		3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	77,095.1	75,976.2	1118.9	98.5
		4	83603- Дээд шатны төсвөөс хуваарилсан	25,000.0	18,322.0	6,678.0	73.3

	5	81855- гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	22,700.7	22,700.7	0.0	100.0
	6	80111-байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	13,056.0	10,429.7	2,626.3	79.9
	Нийт		676,734.1	666,207.2	10,526.9	98.44

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулж, "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын батлан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын ажилласан байна.

2024 онд орон тоо 15 төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 15 оронтой ажилласан байна. Шилэн дансны тухай хуулийн нийт 171 мэдээ мэдээлэхээс 171 мэдээлэл хугацаанд нь мэдээллэсэн. Худалдан авах ажиллагаагаар бараа ажил үйлчилгээний 4 зардалд 32,880.3 мянган төгрөг батлагдсанаас 4 бараа ажил үйлчилгээний 29,157.8 мянган төгрөгийн шууд худалдан авалтаар зохион байгуулсан байна. Бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ болон Бараа үйлчилгээний бусад зардалд нийт 52,747.2 мянган төгрөг батлагдсанаас 51,923.1 мянган төгрөг буюу 98,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2024 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.5 худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Номын сан нь 2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтлэх тендер байхгүй ба 2024 онд 12,237.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 5 төсөл боловсруулж төлөвлөсөн. Бичиг хэргийн зардал 1,800.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардал 1,800.0 мянган төгрөг, шуудан холбооны зардал 900.0 мянган төгрөг, ном хэвлэл 5,400.0, бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардал 2,337.0 тус тус шууд худалдан авалтаар гүйцэтгэл гарсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Номын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Төв номын сан 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 451,375.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,027.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй хэмнэлттэй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих бүх мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье